



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ШИНЭ ЭХЛЭЛ
СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/44/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Аудитор: Д.Зэндмэнэ
Утас: 261628 Цахим хаяг: zendmened@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хүлэгтхүннү Аудит ХХК
Захирал: И.Гүррагчаа
Утас: 99100064 Цахим хаяг: gurragchaa@hulegthunnu.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны яам
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ШИНЭ ЭХЛЭЛ
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Н.ОЮУНГЭРЭЛ ТАНАА

2022.02.23 № 07/245
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ Эхлэл сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ Эхлэл сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>137,510,960.34</u>	<u>112,687,875.38</u>
33	АВЛАГА	330,548.00	00.00
335	Бусад авлага	330,548.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	330,548.00	00.00
34	УРЬДЧИЛГАА	00.00	9,646,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	9,646,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	137,180,412.34	103,041,875.38
351	Түүхий эд материал	74,015,900.27	41,054,459.71
35110	Тусгай зориулалттай материал	70,772,782.27	40,309,394.73
35130	Эм боох материал	3,243,118.00	745,064.98
354	Хангамжийн материал	63,164,512.07	61,987,415.67
35410	Бичиг хэргийн материал	3,964,640.00	5,332,750.00
35420	Аж ахуйн материал	33,688,853.37	36,936,609.87
35440	Түлш, шатах тослох материал	4,991,808.80	5,095,865.80
35470	Бусад хангамжийн материал	20,519,209.90	14,622,190.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,700,744,840.49</u>	<u>2,677,700,714.72</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,700,744,840.49	2,677,700,714.72
392	Биет хөрөнгө	2,700,744,840.49	2,677,460,089.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,533,380,583.00	2,533,380,583.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(60,333,101.42)	(108,026,528.90)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	60,800,000.00	18,240,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(60,800,000.00)	(506,666.67)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	270,427,674.24	127,165,196.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	(227,457,984.54)	(67,752,778.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	148,425,850.64	133,512,064.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(102,492,624.43)	(101,746,871.74)
39217	Ном	138,794,443.00	143,195,092.00
393	Биет бус хөрөнгө	00.00	240,625.00
39301	Програм хангамж	825,000.00	247,500.00
39302	Хасагдуулга	(825,000.00)	(6,875.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,838,255,800.83</u>	<u>2,790,388,590.10</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>330,548.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	330,548.00	00.00
413	Өглөг	330,548.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	330,548.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,837,925,252.83</u>	<u>2,790,388,590.10</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,837,925,252.83	2,790,388,590.10
511	Засгийн газрын оруулсан капитал	1,655,454,175.78	1,655,454,175.78
51101	Өмч: - төрийн	1,655,454,175.78	1,655,454,175.78
512	Хуримтлагдсан үр дүн	848,418,718.12	800,882,055.39
51210	Өмнөх үеийн үр дүн	848,418,718.12	838,155,850.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(37,273,795.44)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	334,052,358.93	334,052,358.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,838,255,800.83</u>	<u>2,790,388,590.10</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,276,119,229.05	1,211,545,474.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,149,881,732.05	75,583,574.66
120	Нийтлэг татварын бус орлого	1,149,418,613.00	46,658,111.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,149,418,613.00	46,658,111.66
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	18,588,569.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,647,700.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,136,770,913.00	28,069,542.66
122	Тусламжийн орлого	463,119.05	28,925,463.00
122001	Хандив тусламж /дотоод/	463,119.05	28,925,463.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,126,237,497.00	1,135,961,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,126,237,497.00	1,120,961,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,126,237,497.00	1,120,961,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	15,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	15,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,199,772,322.42	1,248,819,270.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,199,772,322.42	1,248,819,270.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	990,317,098.11	1,120,044,588.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	766,149,857.58	799,112,624.41
210101	Үндсэн цалин	766,149,857.58	799,112,624.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,827,306.00	106,268,932.28
210201	Тэтгэврийн даатгал	67,346,754.00	74,381,077.45
210202	Тэтгэмжийн даатгал	7,923,147.00	8,221,353.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,157,080.00	6,429,242.48
210204	Ажилгүйдлийн даатгал	1,490,941.00	1,567,023.64
210205	Эрүүл мэндийн даатгал	14,909,384.00	15,670,235.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,685,946.73	19,528,409.38
210301	Гэрэл, цахилгаан	5,511,207.00	5,664,775.00
210302	Түлш, халаалт	10,769,330.88	11,719,162.38
210303	Цэвэр, бохир ус	1,905,408.85	2,144,472.00
210304	Байрны түрээс	500,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,531,653.43	16,557,392.56
210401	Бичиг хэрэг	4,897,144.00	5,863,060.00
210402	Тээвэр, шатахуун	1,053,678.05	925,943.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	4,181,493.38	2,008,763.06
210404	Ном, хэвлэл	00.00	3,154,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,399,338.00	4,605,526.50
2105	Нормативт зардал	300,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,193,093.00	25,286,634.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,070,693.00	22,963,714.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	2,000,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	00.00	140,520.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	122,400.00	122,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	60,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,629,241.37	153,290,595.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,364,646.00	72,227,032.36
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,264,595.37	81,063,563.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	209,455,224.31	128,774,681.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,341,797.00	13,605,420.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,521,797.00	13,025,420.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	820,000.00	580,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	194,113,427.31	115,169,261.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	194,113,427.31	115,169,261.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,076,346,906.63</u>	<u>(37,273,795.44)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,076,346,906.63</u>	<u>(37,273,795.44)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,655,454,175.78	334,052,358.93	(225,262,070.98)	1,764,244,463.73
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	(2,666,117.58)	(2,666,117.58)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,655,454,175.78	334,052,358.93	(227,928,188.56)	1,761,578,346.15
Тайлант үеийн үр дүн			1,076,346,906.68	1,076,346,906.68
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,655,454,175.78	334,052,358.93	848,418,718.12	2,837,925,252.83
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(10,262,867.29)	(10,262,867.29)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,655,454,175.78	334,052,358.93	838,155,850.83	2,827,662,385.54
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(37,273,795.44)	(37,273,795.44)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,655,454,175.78	334,052,358.93	800,882,055.39	2,790,388,590.10

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,138,885,197.00</u>	<u>1,154,550,469.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,647,700.00	18,588,569.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,647,700.00	18,588,569.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,647,700.00	18,588,569.00
1200042	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	18,588,569.00
120009	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,647,700.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,126,237,497.00	1,135,961,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,126,237,497.00	1,120,961,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,126,237,497.00	1,120,961,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	15,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	15,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,135,747,463.00</u>	<u>1,139,091,270.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,135,747,463.00	1,139,091,270.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	926,292,238.69	1,010,316,588.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	753,761,345.58	799,072,724.41
210101	Үндсэн цалин	403,057,840.00	440,254,126.51
210102	Нэмэгдэл	272,993,686.90	274,303,908.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,547,924.00	35,814,700.18
210104	Урамшуулал	45,161,894.68	48,699,989.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,094,119.00	106,308,832.28
210201	Тэтгэврийн даатгал	66,613,567.00	74,420,977.45
210202	Тэтгэмжийн даатгал	7,923,147.00	8,221,353.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,157,080.00	6,429,242.48
210204	Ажилгүйдлийн даатгал	1,490,941.00	1,567,023.64
210205	Эрүүл мэндийн даатгал	14,909,384.00	15,670,235.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,685,946.73	19,528,409.38
210301	Гэрэл, цахилгаан	5,511,207.00	5,664,775.00
210302	Түлш, халаалт	10,769,330.88	11,719,162.38
210303	Цэвэр, бохир ус	1,905,408.85	2,144,472.00
210304	Байрны түрээс	500,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,211,423.38	16,761,000.06
210401	Бичиг хэрэг	2,692,330.00	2,499,350.00
210402	Тээвэр, шатахуун	227,100.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	4,181,493.38	1,683,635.06
210404	Ном, хэвлэл	00.00	9,646,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,110,500.00	1,932,015.00
2105	Нормативт зардал	300,000.00	148,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	148,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,790,191.00	33,859,484.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,667,791.00	31,536,564.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	140,520.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	122,400.00	122,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	60,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,449,213.00	34,637,637.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,449,213.00	34,637,637.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	209,455,224.31	128,774,681.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,341,797.00	13,605,420.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,521,797.00	13,025,420.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	820,000.00	580,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	194,113,427.31	115,169,261.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	194,113,427.31	115,169,261.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3,137,734.00</u>	<u>15,459,199.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,137,734.00	15,459,199.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,137,734.00	15,459,199.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,137,734.00	15,459,199.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,137,734.00	15,459,199.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(3,137,734.00)</u>	<u>(15,459,199.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	<u>00.00</u>	<u>00.00</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<u>00.00</u>	<u>00.00</u>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>00.00</u>	<u>00.00</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,130,961,900.00	1,024,381,207.03	106,580,692.97
УРСГАЛ ЗАРДАЛ	1,130,961,900.00	1,024,381,207.03	106,580,692.97
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,114,837,800.00	1,010,775,787.03	104,062,012.97
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	802,804,700.00	799,072,724.41	3,731,975.59
Үндсэн цалин	411,593,900.00	440,254,126.51	(28,660,226.51)
Нэмэгдэл	304,424,500.00	274,303,908.17	30,120,591.83
Унаа хоолны хөнгөлөлт	36,960,000.00	35,814,700.18	1,145,299.82
Урамшуулал	49,826,300.00	48,699,989.55	1,126,310.45
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,378,500.00	106,308,832.28	2,069,667.72
Тэтгэврийн даатгал	76,266,400.00	74,420,977.45	1,845,422.55
Тэтгэмжийн даатгал	8,028,000.00	8,221,353.53	(193,353.53)
ҮОМШӨ-ний даатгал	6,422,400.00	6,429,242.48	(6,842.48)
Ажилгүйдлийн даатгал	1,605,600.00	1,567,023.64	38,576.36
Эрүүл мэндийн даатгал	16,056,100.00	15,670,235.18	385,864.82
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,695,500.00	19,528,409.38	11,167,090.62
Гэрэл, цахилгаан	12,509,100.00	5,664,775.00	6,844,325.00
Түлш, халаалт	13,226,300.00	11,719,162.38	1,507,137.62
Цэвэр, бохир ус	2,960,100.00	2,144,472.00	815,628.00
Байрны түрээс	2,000,000.00	00.00	2,000,000.00
Хангамж, бараа материалын зардал	26,976,400.00	19,790,299.06	7,186,100.94
Бичиг хэрэг	2,588,600.00	2,499,350.00	89,250.00
Тээвэр, шатахуун	2,456,000.00	1,000,000.00	1,456,000.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	6,568,000.00	1,683,635.06	4,884,364.94
Ном, хэвлэл	12,968,000.00	12,675,299.00	292,701.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	384,000.00	00.00	384,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,011,800.00	1,932,015.00	79,785.00
Нормативт зардал	324,200.00	148,500.00	175,700.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	324,200.00	148,500.00	175,700.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,279,900.00	29,489,384.00	15,790,516.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,882,000.00	27,166,464.00	15,715,536.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	00.00
Даатгалын үйлчилгээ	200,000.00	140,520.00	59,480.00
Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	122,400.00	9,500.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	60,000.00	6,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	100,378,600.00	36,437,637.90	63,940,962.10
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,378,600.00	36,437,637.90	63,940,962.10
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,124,100.00	13,605,420.00	2,518,680.00
Бусад урсгал шилжүүлэг	16,124,100.00	13,605,420.00	2,518,680.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,468,100.00	13,025,420.00	2,442,680.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	656,000.00	580,000.00	76,000.00

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,130,961,900.00	1,024,381,207.03	106,580,692.97
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,120,961,900.00	1,005,792,638.03	115,169,261.97
Улсын төсвөөс санхүүжих	1,120,961,900.00	1,005,792,638.03	115,169,261.97
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.00	18,588,569.00	(8,588,569.00)
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	18,588,569.00	(8,588,569.00)
АЖИЛЛАГСДЫН ТОО	48	48	
Удирдах ажилтан	1	1	
Гүйцэтгэх ажилтан	31	31	
Үйлчлэх ажилтан	16	16	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

<i>2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон</i>	<i>/төгрөгөөр/</i>
Үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<u>15,000,000.00</u>
УРСГАЛ ЗАРДАЛ	15,000,000.00
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,000,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,000,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,000,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	<u>15,000,000.00</u>
Нэмэлт санхүүжилтийн орлого	15,000,000.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,000,000.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(2)-(1)	<u>00.00</u>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<u>00.00</u>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>00.00</u>

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ Эхлэл сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хүлэгтхүннү Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Ичинхорол, аудитын менежер Э.Цолмон нар гүйцэтгэж, чанарын хяналтыг гүйцэтгэх захирал И.Гүррагчаа, чанарын хяналтын менежер Е.Оюундэлгэр нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ Эхлэл сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02/01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн эрхэм зорилго нь Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, үнэт зүйл бүхий, хүмүүнлэг, монгол иргэнийг төлөвшүүлэхэд оршино.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургууль нь Монгол улсын бага, суурь, бүрэн дунд боловсролын судалгаа, шинжилгээ, туршилт болон Кембрижийн олон улсын хөтөлбөрөөр монгол, англи хос хэлний сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүд,
- Боловсролын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүд,
- 2021 оны Засгийн газрын 43-р тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”,
- 2021 оны Засгийн газрын 42-р тогтоол “Төлөвлөгөө батлах тухай”,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй боловч сургуулийн дотоод хяналтын ажилтан санхүүгийн үйл ажиллагаанд 4 асуудлын хүрээнд 15 шалгуурыг тодорхойлж шалгалтыг гүйцэтгэсэн бөгөөд шалгалтын үр дүнд 1 асуудалд зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ Эхлэл сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн “нийт зардал”-ыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн “нийт зардал”-ын 1,199,772.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,997.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 47,867.2 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна. Өөрчлөлтийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	330.6	00.0	(330.6)
Урьдчилгаа	00.0	9,646.0	9,646.0
Бараа материал	137,180.4	103,041.9	(34,138.5)
Үндсэн хөрөнгө	2,700,744.8	2,677,700.7	(23,044.1)
Нийт хөрөнгө	2,838,255.8	2,790,388.6	(47,867.2)
Өр төлбөр	330.5	00.0	(330.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,837,925.2	2,790,388.6	(47,536.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,838,255.8	2,790,388.6	(47,867.2)

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл “Cambridge University press”-ийн албан ёсны англи хэлний сурах бичгийн захиалгын урьдчилгаанд шилжүүлсэн 9,646.0 төгрөгөөр нэмэгдсэн,
- Бараа материалын дансны үлдэгдэл нь цаашид ашиглах боломжгүй болж акталсан 36,956.3 мянган төгрөгөөр буурсан,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь тайлант жилд байгуулсан 81,063.6 мянган төгрөгийн элэгдлээр, хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийн залруулгын

10,262.9 мянган төгрөгөөр тус тус буурч, тайлант жилд ТӨБЗГ-ын 505 дугаар тогтоолын дагуу хөрөнгийн анхны үнийг шинэчлэн тогтоосон 28,069.5 мянган төгрөгөөр, хандиваар хүлээн авсан 27,907.7 мянган төгрөгийн хөрөнгийн дүнгээр тус тус нэмэгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,421,353.0 мянган төгрөгөөр, урсгал зарлагыг 1,421,353.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 290,391.1 мянган төгрөгөөр бууруулж 1,130,961.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төслийг 290,391.1 мянган төгрөгөөр бууруулахад 176,622.8 мянган төгрөг нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил, 23,844.3 мянган төгрөг нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлын бууралт голлох нөлөө үзүүлсэн.

Энэ нь 2021 оны Засгийн газрын 43-р тогтоолын 1.2-т “шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх” гэж заасны дагуу шинээр албан тушаал бий болгоход төсөвлөсөн дүнг хассанаас шалтгаалжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,130,961.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,120,961.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 10,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,120,961.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 18,588.6 мянган төгрөг нийт, 1,139,550.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,024,381.2 мянган төгрөгийг зарцуулж, 115,169.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нийт зардал 1,024,381.2 мянган төгрөг буюу 90.6 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь үйл ажиллагааны урсгал зардлыг 104,062.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 2,518.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Үйл ажиллагааны зардлыг 104,062.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 63,941.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 15,715.5 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 11,167.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой.

Хүснэгт-2 Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
	код	нэр				
1	71802	Ерөнхий боловсрол	1,130,961.9	1,024,381.2	106,580.7	90.6
1.1	80101	Үйл ажиллагааны зардал	1,114,837.8	1,010,775.8	104,062.0	90.7
1.3	80202	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	16,124.1	13,605.4	2,518.7	84.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн хүрээнд төрийн бус байгууллагаас 15,000.0 мянган төгрөгийн хандивын орлого төвлөрүүлсэн.

Үүнээс 4,552.2 мянган төгрөгийг үндсэн хөрөнгө худалдан авахад, 987.8 мянган төгрөгийг хангамжийн материалд, 9,460.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 2 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 90.6 хувийн биелэлттэй, 9.4 хувь буюу 106,580.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийн биелэлт болон түүнийг хэрэгжүүлэхээр баталсан төсвийн гүйцэтгэлийн биелэлт 9.4 хувь буюу 106,580.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь төсвийг хэмнэлттэй зарцуулж сургууль хүрэх үр дүндээ хүрч ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд эко сургуулийн сургалтын төлбөрт 820.0 мянган төгрөгийг “Байгаль орчны мэдээлэл сургалтын төв” төрийн бус байгууллагад шилжүүлсэн, Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу 106,580.7 мянган төгрөгийн зардал хэмнэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Сургуулийн эзэмшилд буй барилгын газар эзэмших эрх нь өөр сургуулийн нэр дээр бүртгэлтэй бөгөөд уг асуудлыг шийдвэрлүүлэхээр сургуулийн удирдлага ТӨБЗГ, харьяа яам болон Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хандсан боловч уг асуудал одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу дараах байдлаар нийцлийн аудитын асуудлыг тайланд тусгасан болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ Эхлэл сургууль нь 2021 онд нийт 1,273,657.2 мянган төгрөгийн 18 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулахаас "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ" хэсэгт орлогын 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 24,026.0 мянган төгрөгийн зардлын 3 мэдээллийг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар албан шаардлага өгсөн боловч уг зөрчлийг дахин давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх"; 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"; 5.5 "шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2 заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна", Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйлд "Албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох албан шаардлага өгөх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2021 оны Б/01 дүгээр тушаалаарх цалин хөлсийг Засгийн газрын 2019 оны 276, 25, 472 дугаар тогтоолын дагуу тогтоож, нэмэгдэл цалинг 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу тооцож олгосон эсэхийг шалгахад төрийн үйлчилгээний албан хаагчид олгох мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 1 ажилтанд илүү олгосныг нөхөн төлүүлж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 4 ажилтанд дутуу олгосныг нөхөн олгож, холбогдох тайлангуудыг залруулав.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад илүү олгосон цалинг 12 дугаар сарын цалингаас суутган тооцсон бөгөөд дутуу тооцож олгосон цалинг нөхөж олгож тухайн ажилчдыг хохиролгүй болгов.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, 2021 оны баталсан цалингийн сүлжээ Засгийн газрын 2019 оны 276, 25, 472 дугаар, 2018 оны 382 дугаар тогтоолтой тус тус нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт илрүүлсэн зөрчлөөс 12,869.42 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,475,081.7 мянган төгрөгийн зөрчилд 2,474,751.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 330.6 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн биелэлт 90 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Биелэлтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	2,474,751.1	1	2,450,725.1	1	24,026.0	80.0
Зөвлөмж	4	330.6	4	330.6	0	00.0	100.0
Нийт дүн	6	2,475,081.7	5	2,451,055.7	1	24,026.0	90.0

Үүнээс 4 зөвлөмж, 1 албан шаардлагыг бүрэн биелүүлсэн, шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон, дутуу мэдээлсэн, цаашид давтан гаргахгүй байх талаар өгсөн 1 албан шаардлагыг бүрэн биелүүлж ажиллаагүй, 24,026.0 мянган төгрөгийн зөрчил давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сургуулийн эзэмшилд буй барилгын газар эзэмших эрх нь өөр сургуулийн нэр дээр бүртгэлтэй бөгөөд уг асуудлыг шийдвэрлүүлэхээр сургуулийн удирдлага ТӨБЗГ, харьяа яам болон Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хандсан боловч уг асуудал одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байгааг ТЕЗ-ийн аудитаар үргэлжлүүлэн үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илрүүлсэн нийт 12,865.4 мянган төгрөгийн 3 алдааг залруулав.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг 10,494.2 мянган төгрөгөөр дутуу, 122.0 мянган төгрөгөөр илүү тооцоолсныг санхүүгийн тайланд,
2. Мэргэшсэн нягтлан бодогчийн зэргийн нэмэгдлийг 655.5 мянган төгрөгөөр илүү олгосныг аудитын явцад холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, 302.2 мянган төгрөгийн илүү тооцоолсон НДШ, ХХОАТ-ын дүнг холбогдох тайлангуудад,
3. Нэр бүхий 4 ажилтны төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 1,001.8 мянган төгрөгөөр дутуу тооцож олгосныг аудитын явцад нөхөн олгуулж, 289.7 мянган төгрөгийн дутуу тооцсон НДШ, ХХОАТ-ын дүнг холбогдох тайлангуудад тус тус залруулав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ Эхлэл сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
							Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ Эхлэл сургууль	АХГ-2022/44/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 10,494.2 мянган төгрөгөөр дутуу, 122.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байна.	СБТ-д ҮХ-ийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг залруулсан	1	10,616.2	1	10,616.2						
2	Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ Эхлэл сургууль	АХГ-2022/44/НА-СТА-ТШЗ	Мэргэшсэн нягтлан бодогчийн зэргийн нэмэгдлийг 655.5 мянган төгрөгөөр, үүнээс тооцох НДШ, ХХОАТ-ын дүнг 302.2 мянган төгрөгөөр тус тус илүү тооцож нэмэгдлийг олгосон байна.	СҮДТ-д цалингийн зардлыг залруулж, илүү олгосон цалинг нөхөн төлүүлсэн	1	957.7	1	957.7						
3	Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ Эхлэл сургууль	АХГ-2022/44/НА-СТА-ТШЗ	Нэр бүхий 4 ажилтны төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 1,001.8 мянган төгрөгөөр, үүнээс тооцох НДШ, ХХОАТ-ын дүнг 289.7 мянган төгрөгөөр тус тус дутуу тооцож нэмэгдлийг олгосон байна.	СҮДТ-д цалингийн зардлыг залруулж, дутуу олгосон цалинг нөхөн олгуулсан	1	1,291.5	1	1,291.5						
ДҮН					3	12,865.4	3	12,865.4						
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал														
1	Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ Эхлэл сургууль	АХГ-2022/44/НА-СТА-ТШЗ	Шилэн дансанд байршуулах мэдээллээс "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ" хэсэгт орлогын 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 24,026.0 мянган төгрөгийн зардлын 3 мэдээллийг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар албан шаардлага өгсөн боловч уг зөрчлийг дахин давтан гаргасан байна.	Өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, холбогдох ажилтанд хариуцлага тооцох	1	24,026.0					1	24,026.0	1	24,026.0
ДҮН					1	24,026.0					1	24,026.0	1	24,026.0
НИЙТ ДҮН					4	36,891.4	3	12,865.4			1	24,026.0	1	24,026.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 108/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/44/НА-СТА-ТШЗ

Сахилгын шийтгэл тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ Эхлэл сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ" хэсэгт 13,500,000.00 төгрөгийн орлогын 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 24,026,000.00 төгрөгийн зардлын 3 мэдээллийг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар албан шаардлага өгсөн боловч уг зөрчлийг дахин давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх"; 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"; 5.5 "шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2 заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна", Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйлд "Албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухайн хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2 заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад харуу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь.

Нягтлан бодогч Д.Наранцэцэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Оюунгэрэлд даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТЫГ ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН
ХҮЛЭГТХҮННУ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Ч.ИЧИНХОРОЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264130

\\10.10.10.20\Bichig_Kherag\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-29.Docx

1001080125

